

**БАТЛАВ**  
 ХАН-УУЛ ДҮҮРГҮЙН ЗАСАГ ДАРГЫН  
 ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  
 С.ЭНХБАЯР  
 2023 оны 12 дугаар сарын 25 өдөр

## ТОХИЖИЛТ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН (БАГЦ-2) АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨВ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР

2023 оны 12 дугаар сарын 25-ны өдөр

Улаанбаатар хот

### Ажлын цар хэмжээ:

Энэхүү ажил нь иргэдэд аюулгүй, тохилог орчинд амьдрах, ажиллах таатай нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилготой.

1	Төсөл боловсруулах үндэслэл	- Нийслэлийн Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 26 дугаар тогтоол.
2	Байршил, эдэлбэр газрын хэмжээ	- 2-р хороо Жаргалант үйлчилгээний төв - 22-р хороо ХААИС-ын 1, 3 дугаар байрны орчим - 19-р хороо Гарааш буусан 70а байрны урд талбай - 18-р хороо Хүннү 2222 хорооллын урд автобусны буудал
3	Зориулалт хүчин чадал	- 2-р хороо Жаргалант үйлчилгээний төвийн шатны засвар, шинэчлэлийн ажил - 22-р хороо ХААИС-ын 1, 3 дугаар байрны орчмын авто замын засварын ажил - 19-р хороо Гарааш буусан 70а байрны урд зогсоол. - 18-р хороо Хүннү 2222 хорооллын урд автобусны дулаан буудал төлөвлөх
4	Одоогийн байдал	- 2-р хороо Жаргалант үйлчилгээний төвийн шат эвдэрч муудсан - 22-р хороо ХААИС-ын 1, 3 дугаар байрны орчмын авто зам цөмрөлт үүссэн - 19-р хороо Гарааш буусан 70а байрны урд хоосон талбай - 18-р хороо Хүннү 2222 хорооллын урд битүү автобусны буудал шаардлагатай
5	Төсөл гүйцэтгэх хугацаа	- Захиалагч гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээний хугацааг үндэслэл болгоно.
6	Төслийн захиалагч	- Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар
7	Төсөл гүйцэтгэх байгууллага	- Авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй байгууллага

8	Төсөл гүйцэтгэх үе шат	<ul style="list-style-type: none"> <li>- Талбайн судалгаа, хэмжилт хийж, хорооны Засаг даргатай зөвшилцсөний дараа ажлын тоо хэмжээг захиалагчид танилцуулах.</li> <li>- Хот байгуулалт хөгжлийн газраас архитектур төлөвлөлтийн даалгавар авах, зөвшилцөх</li> <li>- Нийслэлийн Нийтийн тээврийн газартай зөвшөлцөх.</li> <li>- Нийслэлийн замын хөгжлийн газартай зөвшилцөх</li> <li>- Загвар зураг боловсруулж батлуулах.</li> <li>- Ажлын зураг боловсруулах, ажлын технологи хийх аргачлалыг тодорхой харуулсан байх. /магадлал хийгдсэн байх/.</li> <li>- Төсөвт өртөг /магадлал хийгдсэн байх/.</li> </ul>
9	Орон зайн төлөвлөлтөд тавигдах шаардлага	<ul style="list-style-type: none"> <li>- Архитектур орон зай төлөвлөлтийг тус байршлын онцлог, шаардлага, орц гарц, орчны ерөнхий төлөвлөгөөтэй тохижилтын шийдэл гаргаж дулаан автобусны буудал төлөвлөх..</li> </ul> <p><b><u>Зогсоолын байгууламж:</u></b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Байршлын онцлогоос хамааруулан автобусны буудлыг захиалагчтай зөвшилцсөний үндсэн дээр дулаан автобусны буудал төлөвлөх.</li> </ul> <p><b><u>Ногоон байгууламж:</u></b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Монгол орны уур амьсгалд тохирсон шилмүүст болон навчит мод, бут, сөөг, зүлэг тарьж ногоон байгууламжийг нэмэгдүүлэх.</li> <li>- Ногоон байгууламжийг хамгаалсан хайс төлөвлөх.</li> </ul> <p><b><u>Явган зам, талбай:</u></b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Зорчигчдын амрах талбай болон хүний хөдөлгөөнийг салгаж зорчигчдын хөдөлгөөнийг сайжруулах орц гарцыг нэмэгдүүлж төлөвлөх.</li> <li>- Явган хүн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар MNS 6056:2009 стандарт.</li> </ul> <p><b><u>Авто зогсоол:</u></b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Авто замын явах хэсэг, тээврийн хэрэгслийн зогсоол, тэмдэг тэмдэглэгээг стандартын дагуу төлөвлөх.</li> <li>- Авто зогсоолын /БНБД 21-5-10/, автомашины ангилал, ерөнхий шаардлага, Монгол улсын стандарт “MNS:5342:2003”-д нийцүүлж төлөвлөх.</li> </ul> <p><b><u>Бусад:</u></b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолд тавих ерөнхий шаардлага UCS1601B:2022 стандартыг мөрдөх.</li> <li>- Шаардлагатай тэмдэг, тэмдэглээг байршуулах</li> <li>- Гадна гэрэлтүүлэг, хогийн сав гэх мэт тохижилтын бусад элементийг төлөвлөх.</li> </ul>
10	Төсөл боловсруулахад ашиглах материал	<p><b><u>Монгол Улсын хуулиуд</u></b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хот байгуулалтын тухай хууль</li> <li>- Барилгын тухай хууль</li> <li>- Газрын тухай хууль</li> <li>- Усны тухай хууль</li> <li>- Бусад холбогдох хууль</li> </ul> <p><b><u>Норм, нормативууд:</u></b></p>

		<ul style="list-style-type: none"> <li>- Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм /БНБД30-01-04/</li> <li>- Барилгын орчны тохижилтын ажлын норм ба дүрэм /БНБД 3.01-06-90/</li> <li>- Барилга байгууламжийн зураг төсөв боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм</li> <li>- Бусад холбогдох норм, дүрэм</li> </ul>
11	Инженерийн дэд бүтцэд тавигдах шаардлага	<ul style="list-style-type: none"> <li>- Эрчим хүчинд хэмнэлттэй дэвшилтэт технологийн шийдэл ашиглан дулаан автобусны буудал төлөвлөх.</li> <li>- Гадаргуугийн ус зайлуулах шийдлийг орчны байгууламжуудтай уялдуулан нэгдсэн байдлаар иж бүрэн шийдвэрлэх.</li> </ul>
12	Эдийн засгийн тооцоо, төсөв	<ul style="list-style-type: none"> <li>- Эдийн засгийн тооцоо болон төсвийг БНБД 81-95-12 болон эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн программаар тооцох.</li> </ul>
13	Онцгой нөхцөл	<ul style="list-style-type: none"> <li>- Тохижилтын стандарт мөрдөн төлөвлөх.</li> <li>- Гадаргуугийн ус зайлуулалтыг ус хураах талбайн хэмжээнд тооцоо хийж төлөвлөх, ус зайлуулах байгууламжийг цогцоор нь шийдэх.</li> <li>- Инженерийн шугам сүлжээний байгууллагуудын техникийн нөхцөлийг тусгах, ажлын зураг боловсруулах, холбогдох байгууллагатай зөвшилцөх, ажлын зургийг батлуулах.</li> <li>- Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчинг бүрдүүлэх зорилгоор зам талбайн болон хөдөлгөөн зохион байгуулалтын арга хэмжээ, тоноглол, замын холбогдох байгууламжуудыг тусгасан байх.</li> <li>- Тээврийн хэрэгслийн ил зогсоолыг төлөвлөх, байгуулахад тавих ерөнхий шаардлага UCS 0902B стандартыг мөрдөх.</li> <li>- Барилга, замын ажил гүйцэтгэхэд иргэдийн аюулгүй байдлыг хангах ерөнхий шаардлага UCS 0301B стандартыг мөрдөх.</li> <li>- Улаанбаатар хотын "Нэг хот, Нэг стандарт"-ын эмхэтгэл болох UCS стандартуудыг мөрдөж ажиллах.</li> </ul>

- Зураг төсвийг боловсруулахдаа даалгаварт заасан нэр, зориулалтыг өөрчлөхгүйгээр төсөвт өртөгт багтаах. Төсөвт өртөг хэтэрсэн тохиолдолд эскиз зураг батлагдахгүй болно.
- Эрүүл аюулгүй, галд тэсвэртэй, чанарын шаардлага хангасан материал сонгох (БНБД-д заасан). Зөвшөөрөгдсөн лаборатори, гарал үүслийн, сертификаттай баталгаат материалыг ашиглах.

ХЯНАСАН:

ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН

ХЭЛТСИЙН ДАРГА

Л.ОТГОНБАЯР

БОЛОВСРУУЛСАН:

ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН

ИНЖЕНЕР

М.БАЯРБЯМБА